БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/105/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Баянхонгор<br>2021 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням<br>Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Аудитор: Ж.Өсөхбаяр<br>Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 7
3. Аудитын тайлан ... 8
3.1 Ерөнхий зүйл ... 8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ... 8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ... 9
3.4 Материаллаг байдал ... 9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ... 9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ... 10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ... 11
3.8 Аудитын гол асуудал ... 11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ... 11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ... 11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ... 12
4. Аудитын илрүүлэлт ... 12
4.1 Залруулсан алдаа ... 12
4.2 Төлбөрийн акт ... 12
4.3 Албан шаардлага ... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ... 13

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.07 № 2/01

танай ______ -ны № ______ -т

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.МӨНХЖАРГАЛ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

0050?0171

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **26,052,147.75** | **44,710,794.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 26,052,147.75 | 44,710,794.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 14,187,117.75 | 18,345,764.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 14,187,117.75 | 18,345,764.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 731,980.00 | 732,300.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 11,133,050.00 | 25,632,730.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 159,750.00 | 757,750.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,439,200.00 | 12,448,700.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 49,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,534,100.00 | 12,376,780.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **943,799,372.84** | **1,114,995,307.53** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 943,799,372.84 | 1,114,995,307.53 |
| **392** | **Биет хөрөнгө** | 929,499,372.84 | 1,100,695,307.53 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 919,078,168.00 | 919,078,168.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -31,260,172.32 | -46,890,258.48 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 28,000,000.00 | 28,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -28,000,000.00 | -28,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 193,263,647.17 | 299,254,437.17 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -181,777,316.49 | -95,786,785.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,014,800.00 | 81,014,800.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -52,377,646.92 | -57,532,946.76 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,557,893.40 | 1,557,893.40 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 14,300,000.00 | 14,300,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,900,000.00 | 14,900,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -600,000.00 | -600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **969,851,520.59** | **1,159,706,101.53** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **969,851,520.59** | **1,159,706,101.53** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 969,851,520.59 | 1,159,706,101.53 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 14,300,000.00 | 14,300,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 14,300,000.00 | 14,300,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 664,601,154.67 | 854,455,735.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 664,601,154.67 | 664,601,154.67 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 189,854,580.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 290,950,365.92 | 290,950,365.92 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **969,851,520.59** | **1,159,706,101.53** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **776,972,359.41** | **967,321,780.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **24,185,059.41** | **273,818,080.90** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 24,185,059.41 | 273,818,080.90 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,185,059.41 | 273,818,080.90 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 24,185,059.41 | 273,818,080.90 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **752,787,300.00** | **693,503,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 581,872,900.00 | 602,284,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 581,872,900.00 | 602,284,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 170,914,400.00 | 91,218,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 170,914,400.00 | 91,218,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **792,362,007.74** | **775,744,699.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **792,362,007.74** | **775,744,699.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 790,146,551.74 | 771,399,453.96 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 453,660,729.00 | 459,200,445.21 |
| 210101 | Үндсэн цалин | 385,027,668.00 | 384,293,245.21 |
| 210102 | Нэмэгдэл | 59,750,561.00 | 57,403,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,882,500.00 | 17,504,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,959,921.00 | 69,463,612.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,589,040.10 | 52,920,555.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,657,534.65 | 4,197,572.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,658,826.10 | 3,358,057.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 799,066.17 | 816,957.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,255,453.98 | 8,170,471.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,624,095.00 | 47,794,399.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,747,699.00 | 2,352,483.00 |
| 210302 | Түлш, халаалт | 46,871,300.00 | 44,083,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,005,096.00 | 1,358,616.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,360,189.00 | 22,784,405.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,054,190.00 | 9,495,530.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,867,700.00 | 5,081,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,296,299.00 | 2,633,853.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,842,000.00 | 2,999,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 1,974,222.80 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,668,938.90 | 33,279,810.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 333,100.00 | 568,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,247,838.90 | 32,411,810.00 |
| 210604 | Урсгал засвар | 88,000.00 | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 72,000.00 | 211,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 72,000.00 | 211,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,248,217.70 | 11,431,637.95 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 517,000.00 | 694,064.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 280,000.00 | 330,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,000.00 | 57,200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 13,974,717.70 | 10,208,373.95 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 191,552,461.14 | 127,233,943.21 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 167221700.00 | 91217040.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 488,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,330,761.14 | 35,528,903.21 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,215,456.00 | 4,345,246.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 | 345,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 345,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,815,456.00 | 4,000,246.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,815,456.00 | 3,998,386.00 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1860.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-15,389,648.33** | **191,577,080.94** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 1,722,500.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -1,722,500.00 |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-15,389,648.33** | **189,854,580.94** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **971,628,376.39** | **940,693,081.33** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **28,847,258.50** | **16,893,305.70** |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 28,847,258.50 | 16,893,305.70 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 28,847,258.50 | 16,893,305.70 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 28,847,258.50 | 16,893,305.70 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **189,993,817.89** | **230,296,075.63** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 189,993,817.89 | 230,296,075.63 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 189,993,817.89 | 230,296,075.63 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 189,993,817.89 | 230,296,075.63 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **752,787,300.00** | **693,503,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 581,872,900.00 | 602,284,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 581,872,900.00 | 602,284,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 170,914,400.00 | 91,218,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 170,914,400.00 | 91,218,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **971,628,376.39** | **940,693,081.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **971,628,376.39** | **940,693,081.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **750,571,844.00** | **689,158,454.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 444,579,450.00 | 456,458,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 373,835,250.00 | 377,714,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 61,240,200.00 | 61,240,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,504,000.00 | 17,504,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 65,041,200.00 | 72,205,358.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,521,900.00 | 56,741,058.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,379,800.00 | 3,619,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,503,900.00 | 3,158,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 876,000.00 | 789,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,759,600.00 | 7,896,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,624,095.00 | 47,794,399.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,747,699.00 | 2,352,483.00 |
| 210302 | Түлш, халаалт | 46,871,300.00 | 44,083,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,005,096.00 | 1,358,616.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,690,199.00 | 17,927,683.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,362,200.00 | 7,318,330.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,867,700.00 | 5,081,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,296,299.00 | 2,633,853.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 297,000.00 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,867,000.00 | 2,294,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,415,800.00 | 1,632,810.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 761,400.00 | 833,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 566,400.00 | 499,810.00 |
| 210604 | Урсгал засвар | 88,000.00 | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 72,000.00 | 211,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 72,000.00 | 211,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,273,500.00 | 1,223,264.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 517,000.00 | 694,064.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 280,000.00 | 330,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,000.00 | 57,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 170,875,600.00 | 91,705,040.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 170875600.00 | 91217040.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 488,000.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **221,056,532.39** | **251,534,627.33** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 | 345,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 345,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 191,809,273.89 | 234,296,321.63 |
| 213302 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 189993817.89 | 230296075.63 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,815,456.00 | 3,998,386.00 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг /Нэмэлт санхүүжилт/ | 0.00 | 1860.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 28,847,258.50 | 16,893,305.70 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,847,258.50 | 16,893,305.70 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 14,300,000.00 | 290,950,365.92 | 679,990,803.00 | 985,241,168.92 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **14,300,000.00** | **290,950,365.92** | **679,990,803.00** | 985,241,168.92 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -15,389,648.33 | -15,389,648.33 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **14,300,000.00** | **290,950,365.92** | **664,601,154.67** | 969,851,520.59 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **14,300,000.00** | **290,950,365.92** | **664,601,154.67** | 969,851,520.59 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **14,300,000.00** | **290,950,365.92** | **664,601,154.67** | 969,851,520.59 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 189,854,580.94 | 189,854,580.94 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **14,300,000.00** | **290,950,365.92** | **854,455,735.61** | 1,159,706,101.53 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 602,284,800.00 | 598,286,414.00 | 3998386.00 | 99.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 602,284,800.00 | 598,286,414.00 | 3998386.00 | 99.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 601,939,200.00 | 597,941,414.00 | 3997786.00 | 99.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 456,458,700.00 | 456,458,700.00 | 0.00 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 377,714,500.00 | 377,714,500.00 | 0.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 61,240,200.00 | 61,240,200.00 | 0.00 | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,504,000.00 | 17,504,000.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 75,789,500.00 | 72,205,358.00 | 3584142.00 | 95.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,995,800.00 | 56,741,058.00 | 3254742.00 | 94.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,948,400.00 | 3,619,000.00 | 329400.00 | 91.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,158,700.00 | 3,158,700.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 789,700.00 | 789,700.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,896,900.00 | 7,896,900.00 | 0.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,794,400.00 | 47,794,399.00 | 1.00 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,734,000.00 | 2,352,483.00 | -618483.00 | 135.7 |
| 210302 | Түлш, халаалт | 45,548,400.00 | 44,083,300.00 | 1465100.00 | 96.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 512,000.00 | 1,358,616.00 | -846616.00 | 265.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,287,000.00 | 17,927,683.00 | 359317.00 | 98.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,319,000.00 | 7,318,330.00 | 670.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,081,000.00 | 5,081,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,860,000.00 | 2,633,853.00 | 226147.00 | 92.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 728,000.00 | 600,000.00 | 128000.00 | 82.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,299,000.00 | 2,294,500.00 | 4500.00 | 99.8 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,640,000.00 | 1,632,810.00 | 7190.00 | 99.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 840,000.00 | 833,000.00 | 7000.00 | 99.2 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 500,000.00 | 499,810.00 | 190.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 249,600.00 | 211,200.00 | 38400.00 | 84.6 |
| 210702 | Дотоод албан томилолт | 249,600.00 | 211,200.00 | 38400.00 | 84.6 |

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,232,000.00 | 1,223,264.00 | 8736.00 | 99.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 700,000.00 | 694,064.00 | 5936.00 | 99.2 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 330,000.00 | 330,000.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 120,000.00 | 0.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 | 0.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 60,000.00 | 57,200.00 | 2800.00 | 95.3 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 488000.00 | 488000.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 488,000.00 | 488,000.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 345600.00 | 345000.00 | 600.00 | 99.8 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 345,600.00 | 345,000.00 | 600.00 | 99.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 345,600.00 | 345,000.00 | 600.00 | 99.8 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 602,284,800.00 | 598,286,414.00 | 3998386.00 | 99.3 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 602,284,800.00 | 598,286,414.00 | 3998386.00 | 99.3 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 602,284,800.00 | 598,286,414.00 | 3998386.00 | 99.3 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 40.00 | 40.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 32.00 | 32.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07.00 | 07.00 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **170,914,400.00** | **91,217,040.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **170,914,400.00** | **91,217,040.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 170,875,600.00 | 91,217,040.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 170,875,600.00 | 91217040.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 170,875,600.00 | 91,217,040.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **38,800.00** | **00.00** |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 170,875,600.00 | 91217040.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 170,875,600.00 | 91,217,040.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 170,875,600.00 | 91,217,040.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэнийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэх дээдэлж, бүртгэлийн үйлчилгээг шуурхай хүргэдэг Монгол төрийн үйлчилгээний байгууллага байна.
- Бүртгэлийн үйлчилгээг найдвартай, үр дүнтэй, шуурхай явуулах замаар төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, үндэсний эдийн засгийн хөгжлийг дэмжигч байгууллага байна.
- Бүртгэлийн орчин үеийн дэвшилтэт хандлага, арга технологийг нэвтрүүлэгч, суралцагч байгууллага байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 775,744.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,636.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,727.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189854.6 мянган төгрөгөөр буюу 19.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 26,052.1 | 44,710.8 | 18,658.6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 26,052.1 | 44,710.8 | 18,658.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 943,799.4 | 1,114,995.3 | 171,195.9 |
| Үндсэн хөрөнгө | 1,237,814.5 | 1,343,805.3 | 105,990.8 |
| Хуримтлагдсан элэгдэл | (294,015.1) | (228,810.0) | 65,205.1 |
| **Нийт хөрөнгө** | **969,851.5** | **1,159,706.1** | **189,854.6** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 969,851.5 | 1,159,706.1 | 189,854.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **969,851.5** | **1,159,706.1** | **189,854.6** |

Бараа материалын дансны үлдэгдэл 44710.8 мянган төгрөг болж 18658.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал дансны үлдэгдэл өмнөх оноос 4158.6 мянга, аж ахуйн материал 7009.5 мянга, бусад хангамжийн материал 6842.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Улсын бүртгэлийн ерөнхий газраас үнэ төлбөргүй нийлүүлсэн бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,343,805.3 мянган төгрөг болж 105,990.8 мянган төгрөгөөр өссөн нь 204,072.7 мянган төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар, 4,414.1 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн орлого авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 314 дүгээр тогтоолын дагуу 400.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэж, 101,466.0 мянган төгрөгийн хөрөнгийг актлан, 1430.0 мянган төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 314, 681 дүгээр тогтоолууд болон А-1/1694 тоот албан бичгийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас 4,414.1 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч Баянхонгор аймгийн ЗДТГ-аас 8,602.0 мянга, “Койка” ОУБ-аас 195,470.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 314, 720 дугаар тогтоолуудын дагуу нийт 101,466.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,159,706.1 мянган төгрөг болж 189,854.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 189,854.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 651,764.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 651,764.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 133,144.5 мянган төгрөгөөр бууруулж 518,620.4 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 602,284.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 602,284.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 602,284.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 598,286.4 мянган төгрөгийг зарцуулж 3,998.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 598,286.4 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 3,584.1 мянга, хангамж бараа материалын зардлыг 359.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 91,218.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой зардалд 91,217.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан улсын тэмдэгтийн хураамжийг улс болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна. Тайланд онд тус байгууллагын дансаар улсын төсөвт төвлөрүүлэх хураамжийн 230,296.1 мянга, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хураамжийн 16,893.3 мянган төгрөгийн орлого төвлөрснийг улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс 91,218.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна. Тус зардлын гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд гүйцэтгэлийн аудит хийж илэрсэн зөрчилд төлбөрийн акт тогтоон барагдуулсан тул энэ аудитаар авч үзээгүй болно.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 8 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 86.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 775,744.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 16,617.3 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 959,781.9 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 6 гүйлгээг мэдээлсний дараа дахин нэвтэрч засвар хийсний улмаас хугацаа хоцроосон төлөвтэй болсон байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд урсгал төсвийн зарцуулалт нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд нийцсэн  байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9,081.2 мянган төгрөгийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,751.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,1118.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 293.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,338.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх улсын бүртгэлийн хураамжийн орлогоор тус байгууллагын харилцах дансаар 16,893.3 мянган төгрөг төвлөрсөн байхад мөнгөн гүйлгээний тайланд 20,002.2 мянган төгрөгөөр буюу 3,108.9 мянга, улсын төсөвт төвлөрөх орлого 230,306.1 мянган төгрөг төвлөрсөн байхад 230,296.1 мянган төгрөгөөр буюу 10.0 мянган төгрөгөөр тус тус илүү бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар"-ын 6.2 дахь "Мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэхэд шууд аргыг хэрэглэнэ" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.2 Төлбөрийн акт

Тус байгууллага нь 2021 оны 7 дугаар сард нэг албан хаагчийн ээлжийн амралтын 1,338.4 мянган төгрөгийн цалингаас хуулийн дагуу суутгавал зохих нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын нийт 239.9 мянган  төгрөгийг суутган тооцолгүй цалинг олгосон, мөн 01 дүгээр сард ажилчдаас суутгасан хувь хүний орлогын

албан татварыг аймгийн Татварын хэлтэст 54.0 мянган төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв:

### 4.3 Албан шаардлага

Ажиллагсдын 2021 оны 07 дугаар сарын цалинг Нийгмийн даатгалын хэлтэст 1,338.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 1,338.4 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс | 3 | 4,751.2 | 1 | 3,108.9 | 1 | 293.9 | 1 | 1,338.4 | - | - |

______oOo______